



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН З А Х И Р А М Ж

2017 оны 2 дугаар
сарын 15-ны өдөр

Дугаар 38

Улаанбаатар
хот

Зөвлөл байгуулах тухай

1. Дэлхийд Монгол Улсын үнэлэмж, байр суурь, монгол хүний үнэ цэнийг нэмэгдүүлэн таниулах бодлогыг зохицуулах үүрэг бүхий “Үндэсний брэнд”-ийн зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

Дарга	-Монгол Улсын Ерөнхий сайд
Дэд дарга	-Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга
Гишүүд:	-Байгаль орчин, аялал жуулчлалын сайд; -Гадаад харилцааны сайд; -Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд; -Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд; -Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд; -Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын дэд сайд; -Уул уурхай, хүнд үйлдвэрийн дэд сайд; -Зам, тээврийн хөгжлийн дэд сайд.
Нарийн бичгийн дарга	-Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга.

2. Үндэсний брэндийн зөвлөлийн ажлын албыг өөрийн бүтэц дотроо байгуулж, үйл ажиллагааны зардлыг төсвөөсөө санхүүжүүлэхийг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Даажамба)-д даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

Ж.ЭРДЭНЭБАТ

